



IMD WORLD  
COMPETITIVENESS  
CENTER

---

# “ДЭЛХИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2019”-д МОНГОЛ УЛС

---





## АГУУЛГА

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн тухай.....	3
Судалгааны аргачлал.....	5
Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2019.....	5
Институцийн нөлөө .....	8
Монгол Улсын өрсөлдөх чадвар.....	9
Өрсөлдөх чадварын хувьсал .....	12
Давуу болон сул талууд .....	13
Хамгийн таатай хүчин зүйлс .....	15
2019 онд тулгарч буй сорилтууд.....	15
Өрсөлдөх чадварын алтан дүрмүүд.....	16

## **Зураг болон Хүснэгтийн жагсаалт**

Зураг 1: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан.....	4
Зураг 2: Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан.....	4
Зураг 3: Эрэмбэ тооцоолох аргачлал.....	5
Зураг 4: Өрсөлдөх чадварын эрэмбийг газрын зурагт дүрсэлбэл.....	7
Зураг 5: Бүс нутгийн өрсөлдөх чадварын чиг хандлага.....	7
Зураг 6: Өрсөлдөх чадварын хамаарал.....	8
Зураг 7: Монгол Улсын өрсөлдөх чадвар.....	10
Зураг 8: Өрсөлдөх чадварын үндсэн 4 бүлгийн эрэмбэ.....	10
Зураг 9: Өрсөлдөх чадварын дэд бүлгүүдийн эрэмбэ.....	10
Зураг 10: Монгол Улсын хамгийн таатай хүчин зүйлс.....	15
Хүснэгт 1: Тайлангийн үр дүнгээс-Дэлхийн улсуудын өрсөлдөх чадвар.....	6
Хүснэгт 2: Институцийн тогтолцоо хамгийн сайн болон хамгийн муу байгаа орнууд /шалгуур үзүүлэлтийн түвшинд/.....	9
Хүснэгт 3: Өрсөлдөх чадварын дэд бүлгүүдийн эрэмбийн өөрчлөлт.....	11
Хүснэгт 4: Өрсөлдөх чадварын хувьсал.....	12
Хүснэгт 5: Монгол Улсын давуу болон сул талууд.....	13
Инфографик 1: Монгол Улсын өрсөлдөх чадвар.....	9

## ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВИЙН ТУХАЙ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ) нь 2010 онд салбартаа тэргүүлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын санаачилгаар байгуулагдсан улс төрөөс хараат бус, ашгийн төлөө бус байгууллага юм. Бид өрсөлдөх чадварын судалгааг голлох чиглэлээ болгон ажилладаг бөгөөд дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны аргачлалын дагуу Монгол Улсын эдийн засаг, бизнесийн орчныг таатай болгох, түүнчлэн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын өрсөлдөх чадварыг цогц байдлаар судалсаар ирсэн билээ.

Өрсөлдөх чадвар нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд эдийн засаг болон бизнесийн салбарын хүрээнд өргөнөөр хэрэглэгдэх болсон олон талт, цогц ойлголт бөгөөд угтаа “чадавхийг дээшлүүлэхэд” чиглэгддэг. Өрсөлдөх чадварын судалгаагаар бусдаас давуу байдлыг судлахаас илүүтэй тухайн улс, бүс нутаг өөрийн нөөц боломжоо хэрхэн үр дүнтэй ашиглаж, өөрийн гэсэн өрсөлдөх чадварыг бий болгож, амьдрах болоод бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж чадсан эсэхийг судалдаг.

Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэн (ОУУХХ)-ийн дэргэдэх Дэлхийн өрсөлдөх чадварын төв (ДӨЧТ) “Улс орнуудын өрсөлдөх чадвар судлал нь эдийн засгийн шинжлэх ухааны нэгэн салбар

*бөгөөд аливаа орны компаниуд нь илүү өндөр ашиг орлоготой, ард түмэн нь илүү чинээлэг, хангалуун амьдралтай байх орчныг бүрдүүлж, хөгжүүлэх талаар бодит байдал, бодлого хоёрыг харьцуулан судалдаг” хэмээн тодорхойлсон байдаг.*

ЭЗБӨЧСТ нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Швейцарьт төвтэй ОУУХХ-ийн дэргэдэх ДӨЧТ-тэй Монгол Улсын өрсөлдөх чадварын давуу болон сул талын талаар судалгаа шинжилгээ хийхэд албан ёсоор хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар ЭЗБӨЧСТ нь Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд Монгол Улсын мэдээллүүдийг бэлтгэн явуулдаг бөгөөд бие дааж аймгуудын өрсөлдөх чадвар болон дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайланг бэлтгэн гаргаж байна.

**Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан:** ЭЗБӨЧСТ нь “Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан” судалгааг 2012 оноос эхлэн гаргаж байгаа бөгөөд тус судалгаа нь Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн өнөөгийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг

цогц байдлаар тодорхойлоход чиглэгддэг билээ. Аймгуудын өрсөлдөх чадварыг тодорхойлсон энэхүү тайлангаас аймаг орон нутгийн талаарх өргөн хүрээний мэдээлэл болон аймгуудын хөгжлийн чиг хандлага, өрсөлдөх чадварын өсөлт, бууралтын өөрчлөлтийг харах боломжтой.

Зураг 1: Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан



**Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан:** ЭЗБӨЧСТ нь 2017 онд дүүргүүдийн өрсөлдөх чадварыг судлах санаачилга гарган анхны тайлангаа гаргаж байсан бөгөөд өдгөө дүүргүүдийн өрсөлдөх чадварын өөрчлөлт, чиг хандлагыг судалсан судалгааны


2 дахь тайлангаа гаргаад байна. Дүүргүүдийн судалгааны зорилго нь Улаанбаатар хотын болон 9 дүүргийн өрсөлдөх чадварыг хэмжих, өрсөлдөх чадварын давуу, сул талууд, түүнийг сайжруулахад тулгарч буй бэрхшээлүүдийг гаргаж ирэхэд оршдог.

Зураг 2: Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан



## СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг үнэлэх нийт 332 үзүүлэлтийн 235 үзүүлэлтээр өрсөлдөх чадварын индексийг тооцон эрэмбэлдэг. Эдгээр 235 үзүүлэлтийн 143 нь статистик мэдээлэл, 92 нь санал асуулгаас бүрддэг.



## ДЭЛХИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2019

ЭЗБӨЧСТ нь ОУУХХ-ийн дэргэдэх ДӨЧТ-тэй хамтран Монгол Улсаа дэлхийн сайн жишигтэй харьцуулах замаар өрсөлдөх давуу талаа онцлох, сул талуудаа олж харах, улмаар зорилго, зорилтуудаа тодорхойлох чиглэлээр өрсөлдөх чадварын иж бүрэн тайланг 2010 оноос эхлэн олон улсын аргачлалын дагуу боловсруулж, олон нийтийн хүртээл болгосоор ирсэн билээ. “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-г ДӨЧТ 1989 оноос хойш жил бүр гаргасаар ирсэн бөгөөд тус тайлан нь олон улсад нэр хүндтэй улс орнуудын өрсөлдөх чадварыг цогцоор нь харуулдаг судалгааны бүтээл юм.

ЭЗБӨЧСТ нь 2010-2014 оны хооронд 14 улсыг харьцуулан судалдаг “Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан”-г эрхлэн гаргасан бөгөөд 2015 оноос эхлэн дэлхийн 60 гаруй улсын өрсөлдөх чадварыг харьцуулан судалдаг “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан”-д Монгол Улсын мэдээллүүдийг бэлтгэн явуулж байна. “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2019” нь дэлхийн 63 улсыг харьцуулсан тайлан бөгөөд нийт 332 үзүүлэлттэйгээс 235 шалгуур үзүүлэлтээр өрсөлдөх чадварын индексийг тооцон эрэмбэлдэг. Уг 63 улсыг тоон мэдээллийн олдоц, хамтран ажиллах байгууллага, тэдний туршлагаас хамаарч сонгодог билээ. Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг эдийн засгийн тамир


тэнхээ, бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа, засаглалын үр ашиг, дэд бүтэц зэрэг үндсэн дөрвөн хүчин зүйлийн 332 гаруй шалгуур үзүүлэлтээр харьцуулдаг энэхүү тайланд 2015 онд Монгол Улс 61 орноос 57-рт, 2016 онд 60-рт, 2017 онд 63 орноос 62-рт, 2018 онд мөн 62-рт эрэмбэлэгдсэн билээ. Энэ жил Монгол Улс өрсөлдөх чадвараараа хэддүгээрт эрэмбэлэгдэж буйг, өмнөх жилүүдтэй харьцуулсан өсөлт, бууралт, бүс нутгийн эрэмбэ зэргээс гадна Монгол Улсын өрсөлдөх чадварын давуу болон сул талууд, сүүлийн 1 жилийн хугацаанд хамгийн ихээр өөрчлөгдсөн үзүүлэлтүүд, бидэнд тулгарч буй бэрхшээл гэх мэт мэдээллийг энэхүү шинэ тайлангаас харах боломжтой юм.

Хүснэгт 1: Тайлангийн үр дүнгээс-Дэлхийн улсуудын өрсөлдөх чадвар

Ерөнхий үнэлгээ	€мд/€	Оноо	Эдийн засгийн тамир тэнхээ	Засаглалын үр ашиг	Бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа	Дэд бүтэц		
Сингапур	1	100	АНУ	1 Хонг Конг	1 Арабын Нэгдсэн Эмират	1 АНУ		1
Хонг Конг	2	97.9	БНХАУ	2 Арабын Нэгдсэн Эмират	2 Хонг Конг	2 Швейцарь		2
АНУ	3	97.1	Катар	3 Сингапур	3 Ирланд	3 Дани		3
.....								
БНХАУ	14	88.7		БНХАУ ▲	35 БНХАУ	15 БНХАУ ▲		16
.....			ОХУ ▲	31 ОХУ ▲	47 ОХУ ▲	53 ОХУ ▼		37
ОХУ	45	65.2						
.....								
Аргентин	61	49.0	Монгол ▼	58 Монгол ▼	59 Монгол	61 Перу		61
Монгол	62	45.1	Аргентин	61 Грек	60 Венесуэл	62 Монгол		62
Венесуэл	63	20.1	Венесуэл	63 Аргентин	61 Хорват	63 Венесуэл		63

Нийт 63 орноос өрсөлдөх чадвараараа Сингапур, Хонг Конг, АНУ тэргүүлж байгаа бол Аргентин, Монгол, Венесуэл улсууд сүүлийн байруудад орсон байна. БНХАУ өмнөх жилээс нэг байр ухарч 14-т эрэмбэлэгдсэн бол ОХУ өмнөх жилийн адил 45-т эрэмбэлэгджээ.


Зураг 4: Өрсөлдөх чадварын эрэмбийг газрын зурагт дүрсэлбэл:



Тайлбар: Бүдгэрэх тусмаа өрсөлдөх чадвар сайн

Бүс нутгуудын хувьд өрсөлдөх чадвар хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

Зураг 5: Бүс нутгийн өрсөлдөх чадварын чиг хандлага



**Зүүн Азийн** орнуудын өрсөлдөх чадварын эрэмбэ 2016 оноос хойш өссөн байна.

**Хойд Америкийн** хувьд өрсөлдөх чадварын эрэмбэ 2015-2017 онд буурч, 2017-2018 онд өсч, 2019 онд буурсан байна.

**Баруун Европын** орнуудын өрсөлдөх чадварын эрэмбэ тогтвортой байсан хэдий ч 2019 онд буурсан байна.

**Өмнөд Ази, Номхон далай бүс нутагт** 2018 он хүртэл өрсөлдөх чадварын эрэмбэ буурсан ч 2019 онд өссөн байна.

**Зүүн Европын** орнуудын өрсөлдөх чадварын эрэмбэ өссөөр байна.

**Төв Азийн** орнуудын өрсөлдөх чадварын эрэмбэ буурч байна.

**Өмнөд Америкийн** орнуудын өрсөлдөх чадварын эрэмбэ мөн буурсаар байна.





## ИНСТИТУЦИЙН НӨЛӨӨ

Институцийн чадавхи, чанар нь эдийн засгийг урт хугацаанд амжилтад хүргэх гол хөдөлгөгч хүч, таамаглагч юм.

Өрсөлдөх чадварын эрэмбэд эдийн засгийн өөрчлөлтөнд төрийн бодлогын дасан зохицох чадвар (59-рт) болон улс төрийн тогтворгүй байдлын эрсдлийн (61-рт) харилцан хамаарлыг зураг (Зураг 4)-аар харуулав.

Зураг 6: Өрсөлдөх чадварын хамаарал



Эдийн засгийн өөрчлөлтөнд төрийн бодлогын дасан зохицох чадвар болон өрсөлдөх чадварын эрэмбэ хамаарлын коэффициент (-0.75), Улс төрийн тогтворгүй байдлын эрсдэл болон өрсөлдөх чадварын эрэмбэ хамаарлын коэффициент (-0.79) байна.

Дээрх зургаас харахад эдийн засгийн өөрчлөлтөд төрийн бодлогын дасан зохицох чадвар болон улс төрийн тогтвортой байдлын эрсдэл нь өрсөлдөх чадвартай сөрөг хамааралтай болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, бодлого нь зохицолдоогүй, улс төрийн тогтворгүй байдлын эрсдэл өндөр байх нь өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. Үүнээс гадна Монгол Улс институцийн тогтолцоо хамгийн муу орнуудад, тэр дундаа ЗГ-ын бодлого, шийдвэрийн ил тод байдал хангалттай байдаггүй орнуудын тоонд багтсан байна.

Хүснэгт 2: Институцийн тогтолцоо хамгийн сайн болон хамгийн муу байгаа орнууд /шалгуур үзүүлэлтийн түвшинд/

Институцийн тогтолцоо дэд бүлэг-Сонгогдсон үзүүлэлтүүд	Хамгийн сайн			Хамгийн муу		
	Орнууд	Орнууд	Орнууд	Орнууд	Орнууд	Орнууд
Эдийн засгийн өөрчлөлтөд төрийн бодлогын дасан зохицох чадвар /Санал асуулга/	Сингапур	Арабын Нэгдсэн Эмират	Люксембург	Хорват	Грек	Венесуэл
Авлига, хээл хахууль	Финлянд	Дани	Сингапур	Колумб	Перу	Венесуэл
Хууль, эрхзүй, зохицуулалтын орчин	Сингапур	Хонг Конг	Арабын Нэгдсэн Эмират	Грек	Хорват	Венесуэл
Төрийн бодлогын ил тод байдал /Санал асуулга/	Финлянд	Дани	Норвеги	Монгол	Словак	Венесуэл
Хууль тогтоомжийн индекс	Дани	Норвеги	Финлянд	Мексик	Турк	Венесуэл


## МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Монгол Улсын өрсөлдөх чадвар эрэмбийн хувьд 63 орноос Венесуэл улсын өмнө 62-рт хэвэндээ байгаа хэдий ч онооны хувьд өнгөрсөн жилээс буурсан байна.

Инфографик-1: Монгол Улсын өрсөлдөх чадвар



Зураг 7: Монгол Улсын өрсөлдөх чадвар




Зураг 8: Өрсөлдөх чадварын үндсэн 4 бүлгийн эрэмбэ



Монгол Улсын өрсөлдөх чадварын үндсэн дөрвөн бүлгээс “Эдийн засгийн тамир тэнхээ” хамгийн дээгүүр эрэмбэ (58-рт)-тэй байна.

Зураг 9: Өрсөлдөх чадварын дэд бүлгүүдийн эрэмбэ



Монгол Улсын өрсөлдөх чадварын дэд бүлгүүдээс “Үнэ” дэд бүлэг хамгийн дээгүүр эрэмбэтэй байна. Тодруулбал, Манай Улсын хэрэглээний үнийн индекс, амьжиргааны өртөг, орон сууц, оффисын түрээс бусад улсуудтай харьцуулахад бага байна. Харин олон улсын

худалдаа, бүтээмж, үр ашиг, санхүү, менежментийн үйл ажиллагаа, технологийн дэд бүтэц, шинжлэх ухааны дэд бүтэц, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин зэрэг дэд бүлгүүд хойгуур эрэмбэлэгджээ.

Хүснэгт 3: Өрсөлдөх чадварын дэд бүлгүүдийн эрэмбийн өөрчлөлт

ЭДИЙН ЗАСГИЙН ТАМИР ТЭНХЭЭ								
	2015	2016	2017	2018	2019	Дэд бүлгүүдийн эрэмбэ	2018	2019
						Дотоод эдийн засаг	51	42
						Олон улсын худалдаа	61	62
						Олон улсын хөрөнгө оруулалт	61	44
						Хөдөлмөр эрхлэлт	25	59
						Үнэ	1	2
ЗАСАГЛАЛЫН ҮР АШИГ								
	2015	2016	2017	2018	2019	Дэд бүлгүүдийн эрэмбэ	2018	2019
						Төрийн санхүү	60	57
						Татварын бодлого	31	32
						Институцийн тогтолцоо	59	59
						Бизнесийн эрхзүй	52	58
						Нийгмийн тогтолцоо	48	50
БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГЫН АШИГТ АЖИЛЛАГАА								
	2015	2016	2017	2018	2019	Дэд бүлгүүдийн эрэмбэ	2018	2019
						Бүтээмж, үр ашиг	62	62
						Хөдөлмөрийн зах зээл	40	60
						Санхүү	62	62
						Менежментийн үйл ажиллагаа	62	62
						Хандлага ба үнэлэмж	56	45
ДЭД БҮТЭЦ								
	2015	2016	2017	2018	2019	Дэд бүлгүүдийн эрэмбэ	2018	2019
						Үндсэн дэд бүтэц	59	60
						Технологийн дэд бүтэц	62	62
						Шинжлэх ухааны дэд бүтэц	63	63
						Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин	62	63
						Боловсрол	49	53

## ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХУВЬСАЛ

/1 жилийн хугацаанд хамгийн их хувиар өөрчлөгдсөн үзүүлэлтүүд/

Хүснэгт 4: Өрсөлдөх чадварын хувьсал

САЙЖИРСАН		2018	2019	МУУДСАН		2018	2019
<b>4.2.16</b>	Дэвшилт технологийн экспорт (%)	4.03	16.32	<b>2.4.07</b>	Засгийн газрын татаас	0.30	0.71
<b>4.3.02</b>	Судалгаа, хөгжлийн нийт зардал (%)	0.04	0.14	<b>1.5.01</b>	Хэрэглээний үнийн индекс	4.61	7.65
<b>2.1.02</b>	Төсвийн алдагдал (%)	-6.41	-3.37	<b>4.3.18</b>	Хүчин төгөлдөр патентийн тоо	0.7	0.3
<b>1.1.15</b>	Нэг хүнд ногдох ДНБ-ий бодит өсөлт	3.48	4.92	<b>1.2.02</b>	Урсгал тэнцэл	-	-
<b>1.1.14</b>	ДНБ-ий бодит өсөлт	5.1	6.9	<b>1.1.18</b>	Үндсэн хөрөнгийн хуримтлал-Цэвэр өсөлт	10.37	14.62
<b>3.3.14</b>	Хувь нийлүүлэгчдийн эрх	3.42	4.48	<b>4.3.05</b>	Судалгаа, хөгжлийн бизнесийн зардал (%)	36.46	22.45
<b>2.4.05</b>	Хөрөнгийн зах зээл	3.94	5.03	<b>2.4.15</b>	Бизнес эхлэхэд шаардагдах өдрийн тоо	0.01	0.01
<b>4.3.07</b>	Нэг хүнд ногдох судалгаа, хөгжлийн зардал	1.12	1.43	<b>2.4.02</b>	Протекционизм	6.0	8.0
<b>3.4.08</b>	Хэрэглэгчийн сэтгэл ханамж	4.40	5.55	<b>4.1.04</b>	Усны хүртээмж	4.27	2.87
<b>1.2.13</b>	Худалдаа үйлчилгээний экспорт (%)	7.15	9.01	<b>4.1.04</b>	Усны хүртээмж	5.06	3.64
<b>1.2.12</b>	Худалдаа үйлчилгээний экспорт (тэрбум ам.доллар)	0.80	1.00	<b>2.3.11</b>	Ил тод байдал	2.58	1.88
<b>1.2.25</b>	Аялал жуулчлалаас олсон орлого	2.83	3.56	<b>2.5.04</b>	Улс төрийн тогтворгүй байдлын эрсдэл	1.58	1.16
<b>1.2.23</b>	Худалдаа болон ДНБ-ий харьцаа	49.27	61.60	<b>4.2.11</b>	Чадварлаг инженерүүд	4.62	3.44
<b>2.3.08</b>	Ханшийн тогтвортой байдал	0.227	0.177	<b>2.4.09</b>	Төрийн өмчит ААН-үүд	3.27	2.48
<b>1.1.19</b>	Эдийн засгийн уян хатан байдал	2.48	3.03	<b>2.1.11</b>	Тэтгэвэрийн сан	2.30	1.76
				<b>3.3.10</b>	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ (%)	8.86	6.82

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд судалгаа хөгжлийн зардал, төсвийн алдагдал, хөрөнгийн зах зээл, худалдаа үйлчилгээний экспорт, аялал жуулчлалаас олсон орлого, үзүүлэлтүүд хамгийн ихээр сайжирсан бол хэрэглээний үнийн индекс, урсгал тэнцэл, ил тод байдал, тэтгэвэрийн сан зэрэг үзүүлэлтүүд муудсан байна.

Өрсөлдөх чадварын оноо буурахад дээрх үзүүлэлтүүдээс гадна хөдөлмөр эрхлэлт, бизнесийн эрхзүй, хөдөлмөрийн зах зээл, эрүүл мэнд хүрээлэн буй орчин, боловсролын бүлгүүд буурсан нь нөлөөлсөн байна.

# ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД

Хүснэгт 5: Монгол Улсын давуу болон сул талууд

## ДАВУУ ТАЛ

## СУЛ ТАЛ


Эдийн засгийн тамир тэнхээ	Эрэмбэ	Эдийн засгийн тамир тэнхээ	Эрэмбэ
<b>1.1.18</b> Үндсэн хөрөнгийн хуримтлал	1	<b>1.2.17</b> Экспортын төвлөрөл (Түнш орнуудаар)	63
<b>1.5.04</b> Оффисийн түрээсийн үнэ	1	<b>1.2.02</b> Урсгал тэнцэл	63
<b>1.1.14</b> ДНБ-ий бодит өсөлт	2	<b>1.2.12</b> Үйлчилгээний экспорт (тэрбум ам.доллар)	63
<b>1.3.06</b> Дотогш чиглэсэн шууд хөрөнгө оруулалт (ДНБ-д эзлэх хувь)	3	<b>1.2.18</b> Экспортын төвлөрөл (Бараа, бүтээгдэхүүнээр)	63
<b>1.3.08</b> Хувьцаагаар орсон шууд хөрөнгө оруулалт (ДНБ-д эзлэх хувь)	6	<b>1.3.03</b> Хувьцаагаар хийсэн гадаад шууд хөрөнгө оруулалт (Тэрбум ам. доллар)	63
<b>1.1.09</b> Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал (%)	6	<b>1.2.08</b> Бараа, бүтээгдэхүүний экспорт (Тэрбум ам.доллар)	61
<b>1.1.15</b> Нэг хүнд ногдох ДНБ-ий бодит өсөлт	7	<b>1.1.19</b> Эдийн засгийн уян хатан байдал	60
<b>1.5.06</b> Шатахууны үнэ	9	<b>1.3.07</b> Хувьцаагаар орсон шууд хөрөнгө оруулалт (Тэрбум ам.доллар)	59
<b>1.2.09</b> Бараа бүтээгдэхүүний экспорт (%)	14	<b>1.3.04</b> Хувьцаагаар хийсэн гадаад шууд хөрөнгө оруулалт (ДНБ-д эзлэх хувь)	59
<b>1.2.23</b> Худалдаа ба ДНБ-ий харьцаа	19	<b>1.5.01</b> Хэрэглээний үнийн индекс	59
Засаглалын үр ашиг	Эрэмбэ	Засаглалын үр ашиг	Эрэмбэ
<b>2.2.09</b> Хэрэглээний татварын хувь	12	<b>2.2.07</b> Хувь хүний орлогын албан татварын хувь, хэмжээ	63
<b>2.5.14</b> Нэг удаагийн орлого	14	<b>2.4.09</b> Төрийн өмчит ААН	62
<b>2.2.11</b> Нийгмийн даатгалд ажил олгогчийн төлөх хувь	16	<b>2.4.10</b> Өрсөлдөөний эрхзүй	62
<b>2.4.07</b> Засгийн газрын татаас	16	<b>2.3.04</b> Улсын зээлжих чадварын үнэлгээ	61
<b>2.4.19</b> Цомхотголын зардал	20	<b>2.3.05</b> Төв банкны бодлого	61
<b>2.5.06</b> Жини коэффициент	24	<b>2.5.04</b> Улс төрийн тогтворгүй байдлын эрсдэл	61
<b>2.2.01</b> Татварын нийт орлого	24	<b>2.4.02</b> Протекционизм	61
<b>2.2.10</b> Нийгмийн даатгалд ажилтны төлөх хувь	33	<b>2.3.11</b> Ил тод байдал	61

<b>2.4.01</b>	Тарифын саад бэрхшээл	41	<b>2.4.08</b>	Татаас	60
			<b>2.3.08</b>	Ханшийн тогтвортой байдал	60
<b>Бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа</b>					
<b>3.2.04</b>	Удирдах ажилтнуудын цалин урамшуулал	1	<b>3.2.19</b>	Санхүүгийн ур чадвар	63
<b>3.2.01</b>	Цалингийн түвшин	4	<b>3.3.19</b>	Аж ахуйн нэгжийн өр	63
<b>3.2.06</b>	Ажлын цаг	20	<b>3.1.08</b>	Корпораци	62
<b>3.2.10</b>	Дагалдан сургалт	24	<b>3.2.18</b>	Мэргэшсэн ажилчид	62
<b>3.2.20</b>	Авьяас чадварыг татах, ажилд авах	31	<b>3.4.02</b>	Зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлт	62
<b>3.2.16</b>	Эмэгтэй ажиллах хүч	33	<b>3.2.24</b>	Чадварлаг удирдах ажилтан	62
<b>3.5.05</b>	Нийгэм, эдийн засгийн шинэчлэл хийх хэрэгцээ	34	<b>3.1.09</b>	Жижиг, дунд үйлдвэрүүд	62
			<b>3.4.03</b>	Боломж болон аюул	61
			<b>3.3.14</b>	Хувь нийлүүлэгчдийн эрх	61
			<b>3.3.07</b>	Банк, санхүүгийн орчны зохицуулалт	61
<b>Дэд бүтэц</b>					
<b>4.2.01</b>	Харилцаа холбооны салбарт хийсэн хөрөнгө оруулалт	3	<b>4.2.18</b>	Цахим мэдээллийн аюулгүй байдал	63
<b>4.1.21</b>	Аж үйлдвэрийн хэрэгцээний цахилгаан эрчим хүчний үнэ	6	<b>4.2.11</b>	Чадварлаг инженерүүд	63
<b>4.1.07</b>	Хүн амын-Өсөлт	8	<b>4.3.19</b>	Дунд болон дэвшилт технологийн нэмэгдсэн өртөг	63
<b>4.2.16</b>	Дэвшилт технологийн экспорт (%)	15	<b>4.4.26</b>	Бохирдлын асуудал	63
<b>4.2.08</b>	Үүрэн телефоны хэрэглэгчид	26	<b>4.5.15</b>	Дээд боловсрол	63
<b>4.5.07</b>	Ахлах ангид суралцагчид (%)	30	<b>4.3.22</b>	Мэдлэгийн солилцоо	63
<b>4.2.03</b>	Үүрэн телефоны төлбөр	32	<b>4.2.07</b>	Интернэт хэрэглэгчид	62
			<b>4.3.11</b>	Шинжлэх ухааны зэрэг	62
			<b>4.1.04</b>	Усны хүртээмж	62
			<b>4.1.14</b>	Агаарын тээврийн чанар	62

## ХАМГИЙН ТААТАЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Судалгаанд оролцогчид Монгол Улсын эдийн засгийн хувьд хамгийн сайн гэж үзэж буй 5 хариулт сонгосон үр дүн. /Санал асуулгад хариулагчдын хэдэн хувь нь үзүүлэлтийг сонгосон байдлаар/

Зураг 10: Монгол Улсын хамгийн таатай хүчин зүйлс



## 2019 ОНД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД

- Гадаад өрийн эргэн төлөлт нь эдийн засгийн өсөлтөд эрсдэл учруулж болзошгүй
- Удахгүй болох Улсын Их Хурлын сонгууль улс төрийн тогтворгүй байдал, бодлогын залгамжгүй байдлыг авч ирэх магадлалтай
- Сонгуулийн улмаас гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч магадгүй
- Засгийн газрын зардлаас шалтгаалж дотоодын эрэлт нэмэгдсэнээр инфляци өсөх эрсдэлтэй
- Хот, суурин газрын хөрсний болон агаарын бохирдол нийгэм, эдийн засагт хохирол учруулж байгаа зэрэг нь Монгол Улсад хүндхэн сорилт болж байна.



## ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН АЛТАН ДҮРМҮҮД

### I

Хууль эрхзүй, захиргааны тогтвортой, ойлгомжтой орчин бүрдүүлэх

### II

Төр, засгийн үйл ажиллагаа нь ил тод, хариуцлагатай,  
хурдан шуурхай байх

### III

Төсөв, санхүүгийн болон өрийн удирдлагын сахилга баттай байх

### IV

Салбарын болон газарзүйн онцлогуудыг харгалзан үзсэний  
үндсэн дээр эдийн засгаа төрөлжүүлэх

### V

Уламжлалт болон дэвшилт дэд бүтэц, логистикийн үйл ажиллагаанд  
хөрөнгө оруулах

### VI

Өөрсдийн технологиор үйлдвэрлэл эрхлэн, тэрхүү үйлдвэрлэсэн  
бараа бүтээгдэхүүнээ экспортод гаргах чиглэл баримталдаг  
дунд хэмжээний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих

### VII

Олон улсын зах зээл дээр довтлох стратеги, нэмүү үнэлэмж  
бүтээх урих стратеги хоёрын тэнцвэрийг олох, төсвийн  
тэнцлийг зохистой түвшинд барих

### VIII

Аж үйлдвэрлэлийн суурийг дэмжин “Монголд үйлдвэрлэв”  
тодотголтой болгох

### IX

Боловсролын хос системд анхаарах замаар  
(дагалдан сургалт ба дээд боловсрол) залуу үеийн хөдөлмөрийн  
чадавхийг нэмэгдүүлж, залуусын ажилгүйдлийг бууруулах

### X

Шинжлэх ухаан болон шинээр бизнес эрхлэх  
санаачилгуудыг тус тус дэмжих

### XI

Бодлогын түвшинд болон нийгмийн түвшинд өөрчлөлт  
сайжруулалтад түлхэц болохуйц нэгдсэн ойлголтуудтай байх

### XII

Бодитоор сайжирсан өрсөлдөх чадварын амжилтуудаас  
ард түмний сайн сайхан аж төрөхөд хэрэг болохуйц  
бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд хөрөнгө оруулах  
(илүү чанартай зам, эмнэлэг, сургууль, орон сууц гэх мэт)



## **ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ**

- ◆ Сан бизнес центр 9-р давхар,  
Ерөнхий сайд Амарын гудамж 29,  
Сүхбаатар дүүрэг, 14192  
Улаанбаатар хот, Монгол Улс
- ◆ Утас: 976-11-321927  
Факс: 976-11-321926
- ◆ Фэйсбүүк хуудас: [facebook.com/Ursulduhchadvar](https://facebook.com/Ursulduhchadvar)  
Твиттер хуудас: [twitter.com/ursulduhchadvar](https://twitter.com/ursulduhchadvar)
- ◆ Цахим шуудан: [info@ecrc.mn](mailto:info@ecrc.mn)  
Цахим хуудас: [www.ecrc.mn](http://www.ecrc.mn),  
[www.aimagindex.mn](http://www.aimagindex.mn),  
[www.nogoonhutuch.mn](http://www.nogoonhutuch.mn)